

Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2016 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 02 дугаар хуралдаан:

- “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцэн Шадар сайдын ажлын албанд хүргүүлэх,

- “Аж ахуйн нэгж, байгууллагын химийн хорт болон аюулт бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагаатай холбоотойгоор гарч болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө боловсруулах заавар”-ын төслийг хэлэлцэн Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар батлуулах,

- “Далд уурхайн аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах заавар”-ын төслийг хэлэлцэн Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар батлуулах,

- “Гамшгаас хамгаалах сайн дурынхны ажиллах журам”-ын төслийг Шадар сайдын ажлын албанд хүргүүлж, батлуулах,

- “Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын оны тэргүүний хамт олон, оны шилдэг албан хаагчдыг шалгаруулах журам”-ын төслийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар батлуулах,

- “Онцгой байдлын ерөнхий газрын шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн дүрэм”-ийн төслийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар батлуулах,

- “Гамшгийн шалгуур үзүүлэлт, зэрэглэл тогтоох аргачлал”-ыг дахин боловсруулж, дараагийн даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулахаар тус тус шийдвэрлэсэн.

- Улсын нөөц, хүмүүнлэгийн туламжийн газар, Захиргааны удирдлагын газрын үйл ажиллагаанд иж бүрэн шалгалт явуулсан дүнтэй тус тус танилцав.